Булган аймаг Сайхан сумын ЗДТГ-ын дотоод ажлын сарын мэдээ

2015.05.25 Их Хүрэмт

2015 оны 5-дугаар сарыг “Цэвэр-Орчин-2015” сарын аян болгон аймгийн Засаг даргын захирамжаар зарласантай холбогдуулан сумын хэмжээнд цэвэр-орчин сарын аяныг өрнүүллээ.

Дөрвөн түмэн адууны баярыг зохион байгуулахтай холбоотой айл өрхүүдээр Засаг даргын гарын үсэг бүхий уриалгыг 5-р багийн айл өрх бүрээр ЗДТГ-ын ажилтан албан хаагчид тарааж, нийтийн хог цэвэрлэгээнд гарч хоггүй сум болгох уриалгыг хийлээ.

УРИАЛГА

“Сумын өнгө төрх- Манайхаас эхэлнэ” аяны удирамж 2014 оны мал тоолгоогоор малгай сум 40227 толгой адуу тоологдуулж, үлсдэв даяин тэргүүлдэг. Энэ бахдам амжилт маань нутгийн зон олон аялагуа ус, усийн малчид хөдөлмөрчид, адуучид саалчид, хөдөө аж ахуйн салбарт ажилладагсдын нөр их хөдөлмөр бүтээлийн үр дүн юм. Өрөн нутгийн төр захиргааны байгуулагаас адууны баярыг уламжлан 44 бүхэлдэж ажил хийгээд тодорсон. Энэ ажилд сумын хүүхэд сурагчдыг нийт оролцуулж, төр төсвийн байгуулагад, аж ахуйн нэгж хоршоо, хувиараа эрхлэх аж ахуй, нутгийн зөвлөл өрх бүр идэвхтэй оролцсыг уриалж байна. Юуны өмнө өөрийн эзэмшил газар, үл хөдлөх хөрөнгө, хашаа байшин, 00, мүүс, хогийн цэгээ засаж янзалж өнгө үзэмжийг сайжруулж, нэг хороо гудамжаараа нэгдэн хаваагаа нэгэл өнгөөр будах, нэг шугамд тэгшлэх эмх цэгцтэй болгох, гадна гэрэлтүүлэг, машины зогсоол, тэмдэг тэмдэглэгээ, хаяг чимэглэл хийх, бут сөөг, мод тарих, хогтуй цэвэр орчныг бий болгох зорилгоор “Сумын өнгө төрх-Манайхаас эхэлнэ” уриатай 5-р сарын 15-наас 07-р сарын 15-нийг хүртэл 60 хоногийн аяныг өрнүүлж байна. Сумын ЗДТГазар, багийн засаг дарга нарын зүгээс хуулийн хүрээнд болодцоотой бүх л зүйлээр дэмжиж ажиллана.

Аяны хүрээнд идэвх санаачилгатай оролцож, орчин нөхцөлөө сайжруулсан байгуулага, хороо гудамж, аж ахуйн нэгж, хоршоо, компани, хувиараа эрхлэх аж ахуй, бүлийг шагнаж урамшуулна. Шагналын сан нь:

Нэгдүгээр байр - 1.500.000 төгрөг
Хоёрдугаар байр 1.000.000 төгрөг
Гуравдугаар байр 500.000 төгрөг
Тусгай байр Шагнал, өргөмжлөл

Мөн аяны хүрээнд идэвх санаачилгатай оролцсон иргэн, өрх айлыг шагнаж урамшуулна. Шагналын сан нь

Нэгдүгээр байр – 10-н хүрэгтэй хонь
Хоёрдугаар байр 5-н хүрэгтэй хонь
Гуравдугаар байр 5 төлөг
Тусгай байр 1 адуу өгөхөөр тооцсон болно.

Шиннийг санаачилсан, бүтээн байгуулсан, аж ахуйч хямгач, цэвэр ногоон орчин бий болгосон хөдөлмөрч ажилсаг та бүхнийхээ дэмжлэгтэйгээр сумын маань өнгө төрх өөрчлөгдөнө.

Тамга хүндэтгэсэн

Засаг дарга Н. Мэнд-Амар

Гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулагдлаа.

2015 оны 05 сарын 08-ний өдөр бүх нийтээрээ хог цэвэрлэгээний өдөр болгон зарлаж, бүх айл өрх төрийн албан хаагчид хог цэвэрлэж байна.

ЗДТГ-ын хашаанд ажилчид мод тарьлаа.

Цэвэр орчин-Ногоо ирээдүй аяны хүрээнд Сайхан суманд мод тарих үйл ажиллагаа өрнөж байна. ЗДТГ-ын ажилтан албан хаагчид хүн бүр 1 ширхэг мод өөрсдийн гараар гардаж тарьлаа.

Мөн энэ үеэр Сайхан нутагт баярт мэдээ дуулган Өсвөрийн чөлөөт бөхийн улсын аваргаас алтан медаль хүртсэн эгч дүүсийн хүүхдүүд болох Ч.Содбилэг. Б.Бат-Эрдэнэ нар сумын Засаг дарга болон удидлагуудтай уулзаж амжилтаа танилцууллаа. Сумын удирдлагууд хүлээн авч Засаг дарга Н.Мэнд-Амар баяр хүргэж гарын бэлэг гардуулж, цаашид Азийн аваргын тэмцээнд явахад нь дэмжиж тусална гэж амлалаа. Тус бүрдээ нэг, нэг мод тарьлаа.

2015 оны 05 сарын 15-ны энэ өдөр бяцхан 6 настнуудын “Үсэглэлийн баярын арга хэмжээ” болж байна.

2015 оны 05 дугаар сарын 19,20,21-ний өдрүүдэд 6 багийн БИНХурлуудыг зохион байгуулж малчид хөдөлмөрчиддөө

- Багийн ИНХ-аар Аймгийн ИТХ-ын дарга Д.Батсайхан холбогдох хэлтэс агентлагийн дарга нар болон бусад албаны хүмүүс мэдээлэл хүргэлээ
- Сумын удирдлага, сумын ЗДТГ-ын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд:
    - Орон нутгийн мэдээлэл болон Дөрвөн түмэн адууны баярыг зохион байгуулах ажлын явцыг мэдээлсэн
    - 2016 онд ОНХСангаар хийгдэх төсөл арга хэмжээний санал авч эрэмблэсэн.
    - Малчид хөдөлмөрчдийн 2016 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орох өвөлжөө, хаваржаа болон аялал жуулчлалын зориулалтаар эзэмших газрын хүсэлтийг БИНХ-аар хэлэлцсэн. Нийт 6 багийн ..... хүний өргөдлийг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэв.
    - “Багийн хөгжүүлэх сан”-гаас зээл авахаар төслөө ирүүлсэн 8 иргэний хүсэлтийг шийдвэрлэв.

2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр ЕБСургууль сурагчдын эцэг эхтэй хамтран хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан “Хүүхэд насаа дурсая” сэдэвт өдөрлөг зохион байгуулаа.

2015 оны Архивын Ерөнхий газрын Төрийн архивын газрын дарга н.Болд болон албаны хүмүүс, аймгийн архивын газрын дарга М.Саруулзам нар ирж, архивын шалгалт хийх, зөвлөн туслах үйл ажиллагаа явууллаа.

2015 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Аймгийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Нандин, Х.Баттуяа нар “Статистикийн салбарын хөгжил, цаашдын чиг хандлага, хөгжлийн го үзүүлэлт”, мөн багийн Засаг дарга төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нарт малын ашиг шим гарцын судалгааг хэрхэн гаргах талаар сургалт зохион байгууллаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТЗАХМ Н.ЮМЧИНРАГЧАА